

ХААН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН

ХААН Банк ХК ("Банк" гэх) нь Монгол Улсын Компанийн тухай Хуулийн 46.1, 46.5, Банкны Дүрмийн 9.13.14, Банкны Ногдол ашгийн бодлого болон Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ" гэх)-ийн 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоол, мөн Монголбанкнаас ирүүлсэн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/16/361 тоот зөвшөөрлийн дагуу тус Банкны 2024 оны татварын дараах цэвэр ашиг болох 638,514,456,614 (зургаан зуун гучин найман тэрбум таван зуун арван дөрвөн сая дөрвөн зуун тавин зургаан мянга зургаан зуун арван дөрвөн) төгрөгийн 58.5 хувь буюу 373,547,879,300 (гурван зуун далан гурван тэрбум таван зуун дөчин долоон сая найман зуун далан есөн мянга гурван зуу) төгрөгийг нэгж хувьцаанд 195.35 (нэг зуун ерэн таван төгрөг гучин таван мөнгө) төгрөгөөр тооцож, 2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр буюу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрийн байдлаар Банкны хувьцааг эзэмшиж байсан нийт 32,708 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон мөнгөн хэлбэрээр хуваариллаа.

Тус ногдол ашгийг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр ҮЦТХТ ХХК-иар дамжуулан амжилттай хуваарилсан болно. Ногдол ашиг хуваарилалтын дараах байдлаар тус Банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байна.

Он	Татварын дараах цэвэр ашиг (төгрөг)	Ногдол ашиг хуваарилах дүн (төгрөг)	Ногдол ашгийн хувь	Нэгж хувьцаанд ногдох дүн (төгрөг)	Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн тоо
2024	638,514,456,614	373,547,879,300	58.5	195.35	32,708